



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/344

Есөнбулаг сум

Усны тоо бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай, Бугат, Дарив, Тонхил, Төгрөг, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сумдад усны тооллого судалгааны ажлыг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж, тайлагнах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Усны тоо бүртгэл явуулах ажилд шаардагдах хүн хүч тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бэлтгэн, Байгаль орчны сайдын 2006 оны 269 дүгээр тушаалын хавсралт "Усны тоо бүртгэл явуулах журам, заавар, бүртгэлийн маягт"-ын дагуу хөтлөн чанартай гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Батмагнай)-д даалгасугай.

3. Тооллогын ажилд шаардагдах 32,000,000 (гучин хоёр сая) төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт "Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлэхийг Байгаль орчны газар (Д.Батмагнай)-т зөвшөөрсүгэй.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 18 -ны өдрийн 8.144 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:
Гишүүд:

Байгаль орчны газрын дарга
Хүйсийн говь-Цэцэг нуурын сав
газрын захиргааны дарга
Алтайн өвөр говийн сав газрын
захиргааны дарга
Хяргас нуур-Завхан голын сав
газрын захиргааны дарга
Говийн их дархан цаазат газрын А хэсгийн
хамгаалалтын захиргааны дарга
Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн
хамгаалалтын захиргааны дарга
Сумдын Засаг дарга нар
Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

__ оОо __

